



МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 51-263333 Факс: 51-263333
Цахим шуудан: info@med.gov.mn
Цахим хуудас: med.gov.mn

2024.12.19 № 01/2782

танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох танилцуулга, тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудастай.



Эдийн засаг, хөгжлийн яам
Удирдлага
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн
засаг, хөгжлийн сайд
Лувсанням Гантөмөр
2024-12-20 14:38:11

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Эдийн засаг, хөгжлийн яамны хэрэгжүүлэхээр хяналтад авсан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилт болон үр дүнг тодорхойлж, хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг нэгтгэн хэлэлцүүлэх, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

Хоёр. Арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 дахь заалтыг баримтлан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2024 оны жилийн эцсийн байдлаар:

- Монгол Улсын хууль 8 шийдвэрийн 19 заалт;
- Улсын Их Хурлын тогтоол 23 шийдвэрийн 51 заалт;
- Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 8 шийдвэрийн 16 заалт;
- Ерөнхийлөгчийн зарлигийн 2 шийдвэрийн 3 заалт;
- Засгийн газрын тогтоол 31 шийдвэрийн 43 заалт;
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 41 шийдвэрийн 66 заалт;
- Засгийн газрын албан даалгавар 2 шийдвэрийн 10 заалт;
- Ерөнхий сайдын захирамж 1 шийдвэрийн 2 заалт;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 2 шийдвэрийн 2 заалт;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл 1 шийдвэрийн 1 заалт;

Нийт 119 шийдвэрийн 213 заалтын хэрэгжилтийг тайлагнахаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд оруулсан.

Бүрэн хэрэгжсэн, Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэрэгжүүлэх ажил бүрэн хийгдсэн болон Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамааралгүй буюу 100 хувийн хэрэгжилттэй нийт 5 заалтыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтаас хасуулахаар тусгалаа.

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр

д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хугацаа болоогүй	Хяналтаас хасуулах саналтай
1	Монгол Улсын хууль	8	19	-	-
2	Улсын Их Хурлын тогтоол	23	51	1	3
3	УИХ-ын байнгын хорооны тогтоол	8	16	2	-
4	Ерөнхийлөгчийн зарлиг	2	3	-	-
5	Засгийн газрын тогтоол	31	43	-	1
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	41	66	3	1
7	Засгийн газрын албан даалгавар	2	10	-	-
8	Ерөнхий сайдын захирамж	1	2	-	-
9	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	2	2	-	-
10	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл	1	1	-	-
Нийт		199	213	6	5

Дээрх хүснэгтээс үзэхэд хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй 6 заалт, хяналтаас хасуулах саналтай 5 заалт байх бөгөөд нийт 207 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн:

1. Монгол Улсын хуулийн 19 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 15 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 4 заалт, дунджаар 93.6 хувийн үнэлгээтэй.
2. Улсын Их Хурлын тогтоолын 51 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 48 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 2 заалт, хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй 1 заалт дунджаар 98.8 хувийн үнэлгээтэй;
3. Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын 16 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 14 заалт, хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй 2 заалт, дунджаар 100.0 хувийн үнэлгээтэй;
4. Ерөнхийлөгчийн зарлигийн 3 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 3 заалт, дунджаар 100.0 хувийн үнэлгээтэй;
5. Засгийн газрын тогтоолын 43 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 35 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 8 заалт, дунджаар 94.4 хувийн үнэлгээтэй;

6. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 66 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 45 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 18 заалт, хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй 3 заалт, дунджаар 91.4 хувийн үнэлгээтэй;
7. Засгийн газрын албан даалгавар 10 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 5 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 5 заалт, дунджаар 85 хувийн үнэлгээтэй;
8. Ерөнхий сайдын захирамжийн 2 заалтаас, 100 хувийн хэрэгжилттэй 2 заалт, дунджаар 100.0 хувийн үнэлгээтэй;
9. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 2 заалтаас, 100 хувийн хэрэгжилттэй 2 заалт, дунджаар 100 хувийн үнэлгээтэй;
10. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн 1 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 1 заалт, дунджаар 100.0 хувийн үнэлгээтэй байна.

Улсын Их Хурлын тогтоолын 1 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын 2 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 3 заалт, тайлагнах хугацаа болоогүй нийт 6 заалтын үнэлгээг оруулаагүй тооцсон болно.

Дөрөв. Дүгнэлт

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийгдсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 170 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн хэрэгжилттэй, хэрэгжих шатандаа байгаа буюу 70 хувийн хэрэгжилттэй 37 заалт, хяналтаас хасуулах саналтай 5 заалт, хугацаа болоогүй 6, нийт үнэлэгдсэн 207 заалтын хэрэгжилт дунджаар 94.6 хувьтай байна.

Хүснэгт 2. Хяналт, шинжилгээ, үнэлгээний дүн

д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ, %
				100	70	30	0	
1	Монгол Улсын хууль	8	19	15	4	-	-	93.6
2	Улсын Их Хурлын тогтоол	23	51	48	2	-	-	98.8
3	УИХ-ын байнгын хорооны тогтоол	8	16	14	-	-	-	100.0
4	Ерөнхийлөгчийн зарлиг	2	3	3	-	-	-	100.0
5	Засгийн газрын тогтоол	31	43	95	8	-	-	94.4
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	41	66	45	18	-	-	91.4
7	Засгийн газрын албан даалгавар	2	10	5	5	-	-	85.0
8	Ерөнхий сайдын захирамж	1	2	2	-	-	-	100.0
9	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	2	2	2	-	-	-	100.0
10	Үндэсний аюулгүй байдлын хуралдааны тэмдэглэл	1	1	1	-	-	-	100.0
Нийт		119	213	170	37	-	-	94.6

Тав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10.4-т “Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргаж болно.” гэж заасны дагуу тайланг 2000 тэмдэгтэд багтаан ирүүлэх;
2. Газрын хурлаар арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийг хэлэлцэж тайлан, мэдээллийг нэгтгэж цаг хугацаанд нь албажуулж ирүүлэх;
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн “70” хувийн хэрэгжилттэй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
4. Зорилт, арга хэмжээний хүрсэн түвшин, үр дүнг тайлагнахдаа зорилтот түвшинд хүрсэн эсэх болон шийдвэрлэгдсэн гол ажлыг оновчтой, товч тодорхой, үг үсгийн алдаагүй байдлаар бичих.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

--- 000 ---